



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯН-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 07/38

Булган

Г
Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх,
үйл ажиллагааг дэмжих Баян-Өндөр
сангийн журам


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2, 48 дугаар зүйлийн 48.1, 52 дугаар зүйлийн 52.1.2
дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас
ТОГТООХ нь:

- Сумын орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг дэмжих Баян-Өндөр сангийн журмыг хавсралтаар баталсугай.
- Сангийн журмыг мөрдөж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Идэрмөнх)-д үүрэг болгосугай.
- Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Э.Бүжмаа)-д даалгасугай.



0721007

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
ээлжит 07 дугаар хуралдааны 2022
оны 03 дугаар сарын 30-ны өдрийн
07/38 дугаар тогтоолын хавсралт



**ОРОН НУТГИЙН ЧИГ ҮҮРГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ
БАЯН-ӨНДӨР САНГИЙН ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтын дагуу Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий төсвийн бус хөрөнгөөс бүрдсэн орон нутгийн хөрөнгийг төлөвлөх, бүрдүүлэх, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тооцох, түүнд хяналт тавихад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Урьдчилан төлөвлөн нарийвчлан тооцож төсөвт тусгах боломжгүй хүчин зүйлээс шалтгаалан төсвийн жилийн явцад шаардагдаж болзошгүй төсвийн зардлыг нөхөн санхүүжүүлэх, тухайн шатны Засаг даргаас хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, орон нутгийн чиг үүрэгт хамаарах аливаа үйл ажиллагааг дэмжих болон төсвийн бус орлогын эх үүсвэрийг санаачлан бүрдүүлэхэд тухайн сангийн зорилго оршино.

Хоёр. Сангийн эх үүсвэр

2.1. Сангийн орлого нь дараах эх үүсвэрүүдээс бүрдэнэ. Үүнд:

2.1.1 Орон нутгийн өмчйт болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухайн жилийн үйл ажиллагааны цэвэр ашгийн 20 хүртэл хувь;

2.1.2 Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн бүх төрлийн хандив, тусlamж;

2.1.3 Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компани, аж ахуйн нэгжүүдээс нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн санхүүжилт, мөнгөн тусlamж;

2.1.4 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас байгаль орчин болон байгалийн нөөц баялагт учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого;

2.1.5 Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашиглаж хураалгасан зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг борлуулсны орлого;

2.1.6 Байгалийн баялгийг хууль бусаар бэлтгэж борлуулсны орлого;

2.1.7 Орон нутгийн төрийн байгууллагаас хуулиар хориглоогүй асуудлаар аж ахуйн үйл ажиллагаа явуулж олсон орлого

2.1.8 Орон нутгийн өмчтэй байгууллагуудын актлагдсан хөрөнгийг үнэ тогтоон худалдан борлуулсны орлого

2.1.9 Бусад төлөвлөгдөөгүй орлого

Гурав. Сангийн төлөвлөлт, зориулалт

3.1. Санг байгаль, цаг уурын болзошгүй өөрчлөлтийн талаарх судалгаа, урьдчилсан таамаглал, цаашдын төлөв, орон нутгийн төсвийн орлогын боломж, чадавхийг харгалзан тухайн жилийн төсөвт урьдчилан төлөвлөж тусгах боломжгүй дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулан төлөвлөнө. Үүнд:

3.1.1 Байгалийн гамшигт үзэгдэл, гол түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин, хортон мэрэгчид тархах зэрэг байгалийн гамшигт үзэгдлийг даван туулах;

3.1.2 Үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс барилга байгууламж, шугам, сүлжээ, тоног төхөөрөмж эвдрэх, тээврийн хэрэгсэл сүйрэх, цацраг идэвхит болон химиин хорт бодис алдагдах зэрэг техникийн холбогдолтой томоохон осол гарсан тохиолдолд түүнийг таслан зогсоох үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх;

3.1.3 төсвийн жилийн явцад шинээр батлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардлыг санхүүжүүлэх;

3.1.4 Урьдчилан тооцох боломжгүй, цаг үеийн шинжтэй зарим асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах зардал /төсөвт тусгагдаагүй гадаад, дотоодын зочин төлөөлөгчдийг хүлээн авахтай холбогдсон зардал, бусад зардал/;

3.1.5 Үндэсний спорт болон бусад спортын мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх /олон улсын болон улс, орон нутгийн чанартай уралдаан тэмцээнд оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлэх зардал гэх мэт/;

3.1.6 Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагуудаас нэн шаардлагатай санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, Тэгш ой тохиож байгаа байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.1.7 Орон нутгийн бүтээн байгуулалт, дэд бүтцийн ажил үйлчилгээ, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, зураг төслийн ажлуудын зардалыг санхүүжүүлэх;

3.1.8 Байгаль орчинг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг санхүүжүүлэх;

3.1.9 Сумын хэмжээний тэгш ойг тэмдэглэн өнгөрүүлэх зардлыг санхүүжүүлэх;

3.1.10 Газар тариалан эрхлэх, ойжуулалтыг бий болгоход санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.1.11 Цөлжилтийг бууруулах төсөл арга хэмжээг санхүүжүүлэх;

3.1.12 Хадлан, тэжээл бэлтгэх иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжихэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.1.13 Орон нутагт нэн шаардлагатай мэргэжилтэй боловсон хучин бэлтгэхэд сургалтын төлбөрийг санхүүжүүлэх, орон нутагт тогтвортой суурьшилтай ажиллаж амьдрахад шаардагдах зардалд дэмжлэг үзүүлэх;

3.1.14 Сум, орон нутгийн нэрийг тив, дэлхий, улсын хэмжээнд гаргасан иргэдийг шагнах, урамшуулах, хүндэтгэл үзүүлэх;

3.1.15 Сумын Мэргэжлийн холбоод, ТББ-уудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

3.1.16 Бэлчээрийн усан хангамж, ус цэгийг нэмэгдүүлэх, булаг шандны эхийг хашиж хамгаалах зардалыг санхүүжүүлэх, худаг ус гаргасан иргэдэд дэмжлэг үзүүлэх;

3.1.17 Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх;

3.1.18 Хүний хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх;

3.1.19 Оюуны бүтээлүүдийг дэмжихэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.1.20 Нутгийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, хөгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.1.21 Хөдөө аж ахуй, газар тариалангийн төсөл хөтөлбөрүүд болон хөдөөгийн хөгжлийг дэмжихэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.1.22 Боловсрол, соёл, эрүүл мэндийн чиглэлийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.1.23 Гэр хорооплын өнгө үзэмжийг сайжруулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.2. Орон нутгийн үйл ажиллагааг дэмжих сангийн хэмжээ болон зориулалтыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлаар нийт дүнгээр нь батална.

3.3 Орон нутгийн сангийн орлогын хэмжээг энэхүү журмыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд тухайн шатны ИТХ-аар нийт дүнгээр нь орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгон батална.

Дөрөв. Санг зарцуулах шийдвэр

4.1. Сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг улирал бүр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж зарцуулах ба онцгой нөхцөл байдал үссэн үед Засаг даргын зөвлөл болон Онцгой комиссын хурлын шийдвэрийн дагуу зарцуулж болно.

4.2. Сангаас хөрөнгө гаргах тухайн шийдвэрт заагдсан хөрөнгийн нийт хэмжээ нь тухайн жилийн сангийн нийт дүнгээс хэтрэхгүй байна.

4.3 Санг зарцуулах шийдвэр нь сумын Засаг даргын захирамж байна.

4.4 Уг санг зарцуулахдаа 1 дүгээр гарын үсгийг төсвийн өрөнхийлөн захирагч, 2 дугаар гарын үсгийг Санхүүгийн албаны дарга гарын үсэг зурна.

Тав. Санг санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тооцох

5.1. Сангаас зардал гаргах зайлшгүй шаардлага гарсан нөхцөлд хариуцан гүйцэтгэх байгууллага, ажилтан нь уг арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсвийг зардлын зүйлээр хийсэн дэлгэрэнгүй тооцооны хамт саналаа сумын Засаг даргын Тамгын газрын газарт ирүүлнэ.

5.2. Санхүүгийн алба ирүүлсэн төслийг холбогдох хууль тогтоомж, заавар, журам болон тухайн үеийн зах зээлийн үнэ ханштай нийцэж байгаа эсэх, уг арга хэмжээ, төсөлд сангаас хөрөнгө гаргах зайлшгүй шаардлагатай эсэхийг хянан үзэж, Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэнээс санал авч хянуулан сумын Засаг даргын захирамж гаргуулна.

5.3. Сумын Засаг дарга шаардлагатай гэж үзвэл сангаас хөрөнгө гаргах асуудлыг сумын Засаг даргын зөвлөлийн болон онцгой комиссийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж болно.

5.4. Засаг даргын захирамжийг үндэслэн Санхүүгийн алба санхүүжилтийг олгоно.

5.5. Санхүүжилтийг уг арга хэмжээ, төслийн хэрэгжилтийн онцлог, үе шатны ажлын гүйцэтгэлтэй уялдуулан бүрэн болон хэсэгчлэн олгож болно. Хэрэгжүүлж буй арга хэмжээ, төслийн онцлогоос шалтгаалан өхний ээлжинд зарим бэлтгэл ажил /материал, түүхий эд бэлтгэх гэх мэт/ хийгдэх бол урьдчилгаа олгож болох бөгөөд урьдчилгааны хэмжээ нийт зардлын 50 хувиас хэтрэхгүй.

5.6. Тухайн арга хэмжээ, төслийг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш 15 хоногийн дотор гаргаж, сумын Засаг даргын Тамгын газар Санхүүгийн албанад ирүүлнэ.

5.7. Зардлын тайланг гаргахдаа уг арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөвтэй зэрэгцүүлэн гаргаж, байгууллагын дарга, нягтлан бодогч нар гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байхаас гадна үндсэн баримтын нэг хувийг хавсаргана.

5.8. Сангийн эх үүсвэрээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, төслийг хариуцан гүйцэтгэх байгууллага нь зардлыг зохих шийдвэрт заасан хэмжээнээс хэтрүүлсэн тохиолдолд нэмэлт санхүүжилт олгохгүй, харин хэмнэлт гарсан бол төсвийн холбогдох дансанд эргүүлэн шилжүүлнэ.

Зургаа. Тайлагнал, ил тод байдал, хяналт

6.1. Сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлнэ.

6.2. Сангийн зарцуулалтын жилийн эцсийн тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

6.3. Сангийн жилийн эцсийн зарцуулалтын тайланг аудитын дүгнэлтийн хамт уг тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор байгууллагын шилэн данс, цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ. Зарцуулалтын тайланг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаан, холбогдох хороодын хуралд танилцуулж тайлагнана.

6.4. Сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн алба нь сангийн зарцуулалтад хяналт тавьж, зардлын гүйцэтгэл, эх үүсвэрийн үлдэгдлийн мэдээг тооцон гаргаж, дүнг улирал бүр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаан, холбогдох хороод болон сумын Засаг даргад танилцуулж байна.

6.5. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, холбогдох хороод ажлын хэсэг болон түр хороог байгуулж мөн Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйл, 69 дүгээр зүйлүүдэд заасан журмын дагуу сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт, шалгалт хийж болно.

6.6. Төсвийн ерөнхийлөн захирагч сангийн санхүүжилтээр тухайн салбарт хэрэгжүүлсэн тесөл, арга хэмжээний хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавина.

6.7. Сангийн гүйцэтгэлд бүх талын боломжит хөндлөнгийн хяналтыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хэрэгжүүлнэ.

Долоо. Бусад зүйл

7.1. Сангаас олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно.

7.2. Сангийн эх үүсвэрт энэ журмын 2.1-д заасан бүх орлогыг төвлөрүүлнэ. Тус сангийн эх үүсвэр болох орлогыг санд төвлөрүүлэхгүйгээр зарцуулахыг хориглоно.

7.3. Зориулалт бусаар зарцуулсан тохиолдолд тухайн байгууллага төсөвт байгууллага бол батлагдсан төсвөөс нь суутган тооцож, аж ахуйн байгууллага бол тухайн байгууллагын харилцах данснаас үл маргалдах журмаар нөхөн төлүүлэх асуудлыг ажил гүйцэтгэгч, захиалагч байгууллагын хоорондын гэрээ, хэлцэлд тусгасан байна.

7.4. Сангаас эх үүсвэрийг нь гарган санхүүжүүлж байгаа арга хэмжээ, төслийг хэрэгжүүлэхдээ бараа, материал, ажил, үйлчилгээг тухайн үеийн зах зээлийн үнэ, ханшаас дээгүүр бэлтгэсэн буюу гүйцэтгэсэн, хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, үр ашиггүй зардал гаргасан зэргээр хөрөнгийн ашиглалтад зүй бусаар хандсан тохиолдолд тухайн байгууллагын дарга, нягтлан бодогч нарт зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулна. Хэрэв уг асуудал нь авлига, ашиг сонирхлын зөрчил болон эрүүгийн шинжтэй байвал хууль, хяналтын байгууллагад шилжүүлнэ.

-----оОо-----